



## “БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН УДИРДАХ ЗАРЧМУУД” ГЭЖ ЮУ ВЭ?




Бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, хүний эрхэд учирч буй сөрөг нөлөөг бууруулах арилгах, хариуцлагатай бизнесийг дэмжиж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох зорилгоор 2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг (31 зарчим) батлан гаргасан.



## “БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН УДИРДАХ ЗАРЧМУУД” ГЭЖ ЮУ ВЭ?

Энэхүү зарчмууд нь хүний эрхийг ХАМГААЛАХ төрийн үүрэг, ХҮНДЭТГЭХ бизнесийн байгууллагын хариуцлага, зөрчигдсөн эрхийг “СЭРГЭЭХ” төр, бизнесийн үүрэг гэсэн гурван багана дээр суурилдаг.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ыг бодлого, үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэй НҮБХХ-ийн “**Бизнес ба хүний эрх**” Азийн хөтөлбөр Индонез, Малайз, Мьянмар, Тайланд, Шри Ланка, Энэтхэг, Монгол гэсэн 7 улсад хэрэгжиж байна.



НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2015, 2020 онуудад Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайланг хэлэлцээд бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд учруулж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн Газарт зөвлөсөн юм. Энэ ажлын хүрээнд НҮБХХ-ийн хэрэгжүүлж

буй “**Бизнес ба хүний эрх**” Азийн хөтөлбөрт хамрагдах яриа хэлэлцээг ГХЯ амжилттай хийсний дүнд 2021 оны 4 дүгээр сарын 29-нөөс “Бизнес ба хүний эрх төсөл” Монголд албан ёсоор хэрэгжиж эхэлсэн. Тус төслийн хүрээнд “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулахад дэмжлэг үзүүлж байна.

### БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ ТӨСЛИЙН ЗОРИЛТ

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс баталсан “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-д үндэсний бодлого хөтөлбөрийг нийцүүлэх

Бизнесийн салбарт хүний эрхийг хангах асуудлаар олон нийт, бизнесийн байгууллагуудын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх

Бизнесийн үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизмыг бэхжүүлэх

Бизнесийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийн хоорондын хамаарлыг илүү ойлгож, бодлогын арга хэмжээнд тусгах

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД



“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бизнесийн салбарт тулгамдаж буй хүний эрхийн асуудлуудыг тодорхойлох зорилгоор “Бизнес ба хүний эрхийн суурь үнэлгээ” хийхэд дэмжлэг үзүүлж байна. Энэ хүрээнд:

**150** гаруй хууль тогтоомжид шинжилгээ хийж, НҮБ-д илгээсэн хүний эрхийн хэрэгжилтийн тайлан, салбарын судалгаа, статистик зэрэг баримт бичгийн судалгаа хийв.

Нийслэл болон **21** аймгийн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл **1000** орчим хүнийг хамруулсан **21** удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав.

Бизнесийн салбарын **100** гаруй аж ахуйн нэгжийн дунд асуумж судалгаа явууллаа.



“Бизнес ба хүний эрхийн суурь үнэлгээ”-ний урьдчилсан дүнг 2021 оны 12 дугаар сарын 10-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулсан “Хүний эрхийн үндэсний форум”-д танилцууллаа. “Бизнес ба хүний эрхийн суурь үнэлгээ”-нд үндэслэн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаар төр, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, ИНБ-ын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ГХЯ-ны дэргэд байгуулагдан ажиллаж байна.

## ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-д (18-21) хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор бизнесийн байгууллагууд “Хүний эрхийн магадлан шинжилгээ” хийхийг зөвлөсөн байдаг.



Энэхүү зарчмуудыг хэрэгжүүлэх үүднээс уул уурхай, хүнс, ноос ноолуурын салбарын “Сноу филдс” ХХК, “Траст трейд” ХХК, “Эрдэнэс Таван толгой” ХК компаниуд “Хүний эрхийн магадлан шинжилгээ” хийх ажлыг эхлүүлээд байна. НҮБХХ-ийн “Бизнес ба хүний эрх”, “Байгаль орчны засаглал” төслүүд Монголын Ноос Ноолуурын Холбоо, Монголын Хүнсчдийн Холбоо, Эрдэс Баялаг Эмэгтэйчүүдийн Холбоотой хамтран дээрх гурван компанид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж байна.

“Хүний эрхийн магадлан шинжилгээ” хийх сайн туршлагыг бий болгох ажлын хүрээнд энэхүү магадлан шинжилгээнд хөндлөнгийн хяналт тавих мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх бүрэн цогц сургалт зохион байгууллаа.

Бизнесийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин, хүний эрхэд учирч буй сөрөг нөлөө, зөрчлийг бууруулах, арилгах чиглэлээр баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга замыг тусгасан дараах удирдамж, материалуудыг монгол хэлнээ орчуулан хэвлүүлж, түгээж байна.





## ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭН ЭДЛҮҮЛЭХ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд”-ын гурав дахь тулгуур багана болох зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизмыг бэхжүүлэх хүрээнд бизнесийн үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх

- шүүхийн механизм
- шүүхээс бусад төрийн оролцоотой механизм
- төрийн оролцоогүй механизм
- компанийн дотоод механизмуудыг сайжруулах, бий болгох зорилгоор шүүгч, өмгөөлөгч, хуульч, судлаач, иргэний нийгмийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийж, саналыг Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулахад дэмжлэг үзүүлж байна.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлж байна. 2021 онд зочлох үйлчилгээ, барилга, арьс ширний үйлдвэрлэл болон орон нутгийн бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг судалж, дүн шинжилгээ хийх, эрдэмтэн судлаачдын дунд судалгааны сонирхлыг өрнүүлэхэд чиглэсэн жижиг төслүүдийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүллээ.



## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН ДЭЭДЭЛЬЕ

Европын Холбооны санхүүгийн  
дэмжлэгтэй НҮБХХ-ийн  
“БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХ” ТӨСӨЛ

“Бизнес ба хүний эрх” төслийн талаар  
дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл  
[bhrmongolia@gmail.com](mailto:bhrmongolia@gmail.com) хаягт хандана уу.

